

ГЭРИЙН СУРГАЛТ-ХҮҮХДИЙН ХҮМҮҮЖИЛД ҮЗҮҮЛЭХ ЭЕРЭГ НӨЛӨӨЛӨЛ

Б.Пүрэвсүрэн, магистр, ӨМБИС

Abstract: We in this article we Mongolians how we are bringing up children to traditional and modern families and brief about the need to focus on what is lost for. Humans had to be pedagogical necessity originally.

In addition to today's globalized world countries ethnic minorities, some further strengthened. However, itself dependent, rather than seek outside any mistakes in. Let's talk about core issues. Mongolians traditionally classical heritage from centuries ago. We tried to write on only two things in this article.

Children's education should be emphasized. and the character of our country's important position. the future was very important to take the child's education. Knowledge, but people have a bad conscience to respect nature and up. What envy, anger and name-hour bed of increasing state and his struggle for position, lust and tacit? What wages shrink as a result of human greed? also would be a consideration.

We need focus on and always remember clear teaching of the deep meaning that first exalt wisdom pedagogical like God child up to 3 years, treat as charitable up to 3 to 5 years, work hard as servant up to 6 to 13 years old, after 13 years old be a close friend.

Are we paying more focus on children's education not on upbringing of the children. Nevertheless, the proposed idea is first become a person and then to be educated.

Түлхүүр үг: хэрэгцээ, шаардлага, уламжлал, шинэчлэл, хослуулах

Удиртгал

Бид энэхүү өгүүлэлдээ Монголчуудын үр хүүхдээ хүмүүжүүлж ирсэн уламжлал шинэчлэлийг хослуулан хэрэглэж үр хүүхдийнхээ хүмүүжил, боловсролд анхаарах зайлшгүй шаардлага тулгарч байгаа өнөө үед уламжлалт гэрийн сургалтын дэвшилтэт асуудлыг хөндөн судлав.

Хүн төрөлхтөн үүсэж бий болсон цагаасаа эхлэн залгамж хойч үр хүүхдээ сурган хүмүүжүүлэх хэрэгцээ шаардлага гарсан нь дамжиггүй.

Эдүгээ дэлхийн хүн төрөлхтөн асар хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй цаг үед бид амьдарч байна. Хүмүүсийн амьдралын хэв маяг, улс орны хөгжлийн чиг хандлага, салбар, хоорондын зах зээлийн төлөөх өрсөлдөөн, мэдээллийн шинэчлэлт зэрэг маш олон асуудлууд ар араасаа гарч ирж байна.

Монголчууд бидний үр хүүхдээ хүмүүжүүлж ирсэн уламжлал

Монголчууд бид хэдэн зууны тэртээгээс өртөөлөн ирсэн сургалтын (хүмүүжлийн) сонгодог өв уламжлалтай ард түмэн билээ.

Тухайлбал: “Монголын нууц товчоо”-нд Уруйд мэргэдийн дүрвэж дутаасны хойно тэдний

нутаг дээр булган малгайт, марлын годон гуталт, жарх усны булга, хоёрыг зүүсэн нүдэндээ галтай нүүрэндээ цогтой Хүчү гэдэг нэртэй 5 настай хөвгүүн хоцорсныг олж авчирч Өгэлүн эхэд бэлэг болгон өгөв (Монголын нууц товчоо. 2009, х.49).

Тайчуудын Бэсүдийн нутаг дээр Хөхөчү нэртэй нэгэн өчүүхэн хөвүүн хоцорсоныг манайхан олж аваад Өгэлүн эхэд өгч тэжээлгэв (Монголын нууц товчоо. 2009, х.52).

Татаарын хоргодож байсан Нарату Шитүгэний нутаг дээр нэгэн өчүүхэн хүүхэд орхигдсоныг бидний цэргүүд олжээ. Үзвэл дөртэй алтан ээмэг зүүсэн ба булгаар доторлосон даж торгон элгэвч “хантааз” өмссөн ажээ. Тэр хүүхдийг Чингис хаан авчирч, Өгэлүн эхэд бэлэг гэж өгөв. Өгэлүн эх өгүүлрүүн: “Сайн хүний хөвүүн биз язгуур сайт хүний ураг биз 5 хөвгүүний дараах 6 дугаар хөвгүүн болгоё гээд Шихихутаг гэдэг нэр өгч асрав (Монголын нууц товчоо, 2009, х.63).

Тэднийг Өгэлүн эх өөрийн арга сургаалаар хүмүүжүүлж Чингис хааны өдөр үзэх нүд, шөнө сонсох чих болгон хүмүүжүүлэв хэмээн Монголын нууц товчоонд дурьджээ. Үүнээс үзэхэд Монголчууд XIII зууны үед хүүхдийн 5-6 нас хүмүүжлийн хамгийн чухал эгзэгтэй үе гэдгийг мэддэг агуу баялаг уламжлалтай үндэстэн

байв. Оросын нэрт сурган хүмүүжүүлэгч А.С.Макаренко “Хүүхэд 5 хүртэлх насандаа зөв хүмүүжлийн 90 хувийг олж авдаг” гэж бичсэн байдаг нь дээрх жишээг батлах мэт санагдана.

Монголчууд бид хэдэн зуун хуудастай ном бичиж байсан хэдий ч нүүдэлчин ахуй, аян дайны улмаас уламжлагдан ирж чадаагүй байх нь цөөнгүй мөн хойч үеэ сурган хүмүүжүүлэх сургаалаа хоёрхон мөр үгэнд багтаан хүүрнэж хүнээр хүн хийх арга ухаанаа үеэс үед дамжуулан уламжилж ирсэн онцлогтой.

“Хүн болох багаасаа хүлэг болох унаганаасаа”, “Эх нь хээр алаг бол унага нь шийр алаг”, “Эзэн хичээвэл заяа хичээнэ”, “Ажил хийж хүн болдог, ар давж хүлэг болдог”, Эрхийг сурахаар бэрхийг сур, “Эх нь булингартай бол адаг нь булингартай”, “Биеэ мэдвэл хүн, бэлчээрээ мэдвэл мал”, “Бие нь төрмөл, санаа нь тарьмал” гэх мэт зүйр үгээр нас насанд нь тохирсон үг хэллэгийг бага балчираас нь өрх гэртээ болон айл саахалтаараа хамтран сурган хүмүүжүүлж ирсэн уламжлалтай ажээ.

“Бие нь төрмөл, санаа нь тарьмал” гэсэн зүйр цэцэн үгэнд хүнээр хүн хийх сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны зайлшгүйг батлахын хамт хүний хүмүүжилд нийгмийн олон хүчин зүйлс, шинж чанар, орчин нөхцөл чухал нөлөө үзүүлдэг асуудлыг илэрхийлсэн зүйр үг байна. Өвөг дээдсээс минь хуримтлуулсан баялаг туршлагыг “байгалиас төрмөл биед” сургалт хүмүүжлээр дамжуулан өвлүүлэн эзэмшүүлсний үр дүнд нийгмээс “тарьмал санаа” бодол бий болж төлөвшдөг гэсэн гүнзгий санаа тусгагдсан байна.

“Орчин үед хүн хүнээ хайрлах, хүн амьтныг хайрлах, хүн байгаль дэлхийг хайрлах нигүүлсэнгүй сэтгэл доройтсоны гай гамшиг олон зүйлд ил харагдах боллоо” хэмээн дурджээ (Чоймаа, 2015, х.60). Тиймээ бид Ш.Чоймаа багштай санал нэг байна. Сайны хажуугаар саар гэж эрдэм мэдлэг өндөр боловч хүн чанар, биесээ хүндлэх ухамсараар бид мөхөс болж дээ. Атаа жөтөө, уур хилэн, нэр төр, албан тушаалын төлөөх тэмцэл, шунал тачаал, ил далд дангараг ихсэж буй нь цагийн ороо бусгаатай юу? цалин багасаж хүмүүний шунал ихэссэнтэй холбоотой юу? бас бодох зүйлийн нэг болж дээ.

Үр хүүхдээ хүмүүжүүлэх өв уламжлалаа сэргээн санахуй

Ер нь аливаа улс орон, үндэстэн ястан өөрийн онцлог, хэв маяг, амьдралын зан дадал орчин,

нөхцлөөсөө шалтгаалаад сургалт хүмүүжлийн олон хэв маяг дадал хэрэгцээ, сэдэл зарчим зорилго, агуулга, арга хэрэглүүртэй байдаг.

Бид өнөөдөр үр хүүхдээ хүмүүжүүлэхдээ юуг гол баримжаа болгож байна вэ? Хэн нэгнийг даган дуурайж хэрээ галууг дагаж хөлөө хөлдөөв гэдгийн үлгэрийг давтаж байгаа мэт заримдаа санагддагаа нуух юун билээ. Бид дорнын соёлтой ард түмэн. Дорно дахины сурган хүмүүжүүлэх тэр дундаа Монгол уламжлалын онцлог нь гэр бүлсэг, ахмад, эцэг эхийн нэр хүндийн нөлөө их, тэдэнд хүндэтгэлтэй ханддаг билээ. Харин өрнө дахинд бараг эсрэгээрээ байдаг. Тэгвэл бидний өвөг дээдэс хүүхдээ хэрхэн хүмүүжүүлэх ямар өв уламжлалыг бидэнд өвлүүлсэн бэ? Бид ямар сургалтаар дамжин орчин үеийн хүмүүжил сургалтын системд хүрсэн бэ?

Нүүдэлчин Монголчууд танхимын тогтолцоотой сургууль буй болохоос өмнө хүүхдүүдээ гэрийн сургалтаар бичиг үсэг эрдэм номд суралцуулж ирсэн олон зуун жилийн уламжлалтай ажээ.

Тухайлбал, ардын уран зохиолч, академич Ц.Дамдинсүрэн арваад насны үедээ өөрийн эцэг Цэнд мэйрэнгээр монгол бичиг заалгаж, үе тэнгийнхээ хүүхдүүдтэй хошууны жасаа, тамгын газар, бичиг сийрүүлэх, хувьлах ажил хийж байсан тухайгаа хуучилсан байдаг.

Монголчууд хүүхэд багачууддаа цагаан толгой нүдлүүлж, холбож уншиж сурмагц “Оюун түлхүүр”, “Орчлонгийн сав шимийн дуулал”, Равжаа хутагтын “Цагийн жамыг тодруулагч цаасан шувууны сургаал” зэрэг уран яруу шүлэг, сургаал цээжлүүлж боловсрол, хүмүүжил хоёрыг нь тэгш эзэмшүүлдэг байсан байна. Ийнхүү шүлэг, сургаал цээжлэх нь хүүхдийн үзэл санаа төлөвших, ой тогтоомж сайжруулах, үгийн хэрэглээ баяжих, хурдан сэтгэх чадвар нэмэгдэх зэрэг маш олон талын ач тустай тул гэрийн сургалтын энэ сайхан уламжлалт сургаал болох яруу найрагч Данзанравжаагийн “Цагийн жамыг тодруулагч цаасан шувууны сургаал”-ийг үр хүүхдээ ухааруулж хүмүүжүүлж ирсэн бадгаас толилуулж байна.

Аяа бас, шавь хүн ламыг үл ойшооно.

Түүнчлэн хөвгүүн нь эцгийн үгийг үл сонсоно

Хүүхэн хүн эхийн сургаснаар үл явна

Шавь хүн ламаас ноёдыг илүү хүндэлнэ

Хөвгүүн хураахаас тараахыг үйлдэнэ
Хүүхэн хүн эцэг, эхээс эрийг илүү өргөнө
Залуу нь хөгшнөө басна

Хөгшин хүн залуугаа үл тооно

Идрүүд нь хал барина

Мунагсад нь далд орохыг хүснэ

Аяа бас, Үйлийг өр мэт үл санана

Номыг самуун үг мэт үл дурсана

Үхэхийг унтахын төдий үл санана

Рашааныг умдааны төдий үл хэрэглэнэ

Судрыг мөнгө мэт үл хадгална

Сайн үгийг сонсовч мартана

Муу үгийг алба мэт зарлана

Авах бол уул мэт боловч чамлана

Өгөх бол нэг фун ч болов харамлана

Цухалдвал өөрөө ч болов боож үхнэ

Нөхөцвөл хүний төлөө байх юмаан ч бол орхино

Буяныг худалдааны төдий үл хэрэглэнэ хэмээжээ. Энэ хэсэгт юу эрхэм болох, ямар зүйлийг анхааран үр хүүхдээ хүмүүжүүлэх тухай гүн гүнзгий илэрхийлжээ. Зарим нэг мөртийг тайлбарлахад: Хүний хэлсэн хэрэгтэй үгийн анхаарах сонсохгүй, атлаа амьдралд хэрэггүй ховын чанартай үг хэллэгийн дамжуулан дэмий ярих хэрэггүй гэдэг санааг илэрхийлжээ. Хэдэн зуунаар өртөөлөн ирж үнэ цэнэ алдаагүй сонгодог бүтээл учраас бид энэ өгүүлэлдээ иш татан орууллаа.

Монголын нэрт сэтгэгч соён гэгээрүүлэгч Тогтох төр 1735 онд зохиосон “То вангийн 3 үсэгт” хэмээх номдоо:

Номд мэргэн, нойронд сэргэг

Үйлэнд уран, үгэнд цэцэн

Дайнд баатар, далайд усч

Хуульд шударга, хуриманд цовоо

Дээдэд зусаргүй, доодод найртай хэмээн эр хүний 10 эрдэм хэмээх сургаал нь тухайн үеийн монголчуудын сурган хүмүүжүүлэх арга ухааны баялаг уламжлалыг илтгэж байна.

Мөн Тоть шувууны сургаал зохиолд,

Хүүхдийг зөв хүмүүжүүлэхэд уламжлалын үнэт өвийн тухай өгүүлэхдээ:

Үнэн бат журмыг үргэлж сахиж явах

Өвөг дээдийн сургаалийг санаж сэрж явах

Үйлийн дээд ачийг буцааж хариулж явах

Өсөх гээхийн амьдралыг учирлан таньж явах

Үлэмж мэргэн номыг тогтоон тунгааж явах

Үгээгүй дорд ардыг өргөн тэнхрүүлж явах гэж сургасан ажээ. Мөн бид үр хүүхдээ хүмүүжүүлэхэд голлон анхаардаг бас нэг зарчим нь үлгэрлэн дуурайлгах арга ухаанаар сургаж хүмүүжүүлж ирсэн уламжлалтай ард түмэн билээ.

Бидний үр хүүхдийн ямар хүн болох нь мэдээж маш олон зүйлээс шалтгаалах хэдий ч хамгийн гол нь гэр бүл, эцэг эх бид бүхэн мөн билээ. Оросын нэрт сурган хүмүүжүүлэгч В.А.Сухомлинский “Чи хүн болж төрсөн. Гэвч хүн шиг хүн болох ёстой” гэж хэлсэн байдаг нь монгол хүний сурган хүмүүжүүлэх ерөнхий зарчимтай тохирч байгаа юм. Өвөг дээдэс минь гэрийн сургалтаар хүүхдүүдээ гэр бүлийн орчинд хүмүүжүүлэхдээ дээр дурдсанчлан даган дуурайлгах, зүйр цэцэн үг хэллэгийг тогтмол ухамсарлуулан хэлж, оюун ухаанд нь амьдралын нарийн ухааныг суулгадаг байжээ.

Бидний өвөг дээдэс “Хүүхдийг багаас нь хатуу арьс, ширмэл ширдэг дээр унтуулж биеийг нь чангаруулж, 2-3 наснаас нь эхэлж хурга, ишигний зүс нүдлүүлж, гар хөлийн үзүүрт хөдөлгөн, юм дөхүүлэх, ойртуулах зэрэг хүч чадалд нь тохирсон ажил хийлгэдэг байжээ. Хүүхэд хөдөлнө явна гэдэг бол хөдөлмөрлөх үндэс эхэлж байна гэсэн үг” гэж Т.Намжил тэмдэглэжээ. Түүнчлэн “Ажил хийвэл дуустал, давс хийвэл уустал” гэж сургаж ажлыг дуустал хийлгэхийг эрмэлздэг байжээ. Аливаа ажлыг буруу хийвэл зодож, загнахгүйгээр учрыг сайн ойлгуулж тайлбарлах, хөдөлмөрийн сайхныг мэдрүүлэхийн тулд хөдөлмөрийн ач тусыг бодитойгоор үзүүлж өгөх нь бага насны хүүхдэд тун чухал байдаг.

Бидний баялаг сайхан уламжлалтай сурган хүмүүжүүлэх ухаанд хүүхдийг 3 нас хүртэл “Бурхан мэт өргөмжил”, 3-5 насанд нь “Буянтан мэт асар”, 6-12 насанд нь “албат мэт зүтгүүл”, 13 наснаас хойш “анд мэт дотнос” гэсэн маш товч бөгөөд тодорхой гүн утга агуулгатай амьдралын туршлагаар батлагдсан чухал сургаал бий.

Энэхүү сургаалыг дэлхийн дахинаа баталсан нэгэн баталгаа нь маш олон орны эрдэмтэд судлаачдийн хийсэн ажиглалт: Бага насандаа чоно, сармагчин мэтийн хээрийн зэрлэг амьтадтай хамт агуйд амьдарч байгаад эргэж хүмүүст олдсон 27 Магули хүүхдүүдэд нэг нийтлэг зүйл байсан. Тэр бол хүмүүсийн дунд нийгэмших наад захын алхамыг давж чадаагүй. Сар гарахаар чоно

шиг ульдаг, хувцас өмсөж, гал харж чадахгүй, махыг түүхийгээр нь зулгааж иддэг. Орон дээр унтдаггүй, аяганаас хоол идэж чаддаггүй, газарт асган долоож иддэг. Аргагүй тэд 2-5 насандаа адгуусан амьтадтай хамт амьдарч тэдний дадал хэвшилийг олж авсан учраас тэрийгээ өөрчилж нийгэмшиж чаддаггүй байсны баримт юм. Тэдний нэг нь ч бүтэн өгүүлбэр хэлж сураагүй ажээ.

Ганцхан Камала гэх Энэтхэгээс олдсон охин л хүмүүсийн дунд 10 гаруй жил амьдарсан, бусад нь бүгдээрээ хэдэн сар, хэдхэн жил амьдарсан гашуун түүхийг дурдаж болно. Энэ бүхнээс үндэслэн үзвэл Монголчууд бидний хэлээд байгаа “бурхан” нас буюу 2-3 нас ямар чухал эгзэгтэй үе болох нь тодорхой харагдана. Хэрвээ та хүүхдээ энэ насан дээр нь л зөв чиглүүлэхгүй бол хатуухан хэлэхэд хүн дүрстэй “араатан” бэлдэж байгаа байж болох юм.

Сүүлийн жилүүдэд нүд хальтрам, сэтгэл сэрт хийлгэсэн хэрэг явдал гарсаар л байна. Энэ насанд ээж аав, бгш сурган хүмүүжүүлэгч бид бүхэн минь онцгой анхаарах нь чухал байна. Тиймээс бид бүгдээрээ мэддэг гэвч хамгийн гол нь хэрэгжүүлэхгүй байгаад л асуудлын мөн чанар оршсоор байдаг билээ.

ДҮГНЭЛТ

Ардын уламжлалт сурган хүмүүжүүлэх арга ухаанаа умартсан, буруу зөрүү ойлгосон, зарим нь мэддэг ч ач холбогдолыг нь гүнээ ухааран ойлгоогүй, энэ цагт төдийлөн чухал биш гэж үзэх хандлага байсаар байна.

Уламжлал шинэчлэлийг хослуулан монгол өв уламжлал, хэл соёлоороо, монгол хүн болсондоо бахархах иргэдийг үе үеийн эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгчид хүмүүжүүлж ирсэн билээ.

Бид үр хүүхдийнхээ хүмүүжилд төр засаг, эцэг эх, иргэн бүр анхаарлаа хандуулснаар “Зөв Монгол хүүхэд”-ийг төлөвшүүлж чадна.

Өвөг дээдэс минь гэрийн сургалтаар хүүхдүүдээ гэр бүлийн орчинд хүмүүжүүлэхдээ дээр дурдсанчлан даган дуурайлгах, зүйр цэцэн үг хэллэгийг тогтмол ухамсарлуулан хэлж, оюун ухаанд нь амьдралын нарийн ухааныг суулгадаг тэрхүү уламжлалыг ялангуяа залуу гэр бүл эцэг, эхчүүд онцгой анхааран өөрийн амьдралд хэрэгжүүлэх нь чухал болов уу?

Эцэст нь тэмдэглэхэд олон мянган жилийн түүхтэй гэрийн сургалтынхаа дэвшилтэт уламжлалаас хичээнгүйлэн суралцахыг эцэг, эхчүүд, нийт сурган хүмүүжүүлэгчдээсээ хүсье.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Ичинхорлоо, Ш. (2012). *Хүүхдээ хэрхэн хүмүүжүүлэх вэ?*. Улаанбаатар: Соёмбо принтинг
- Ичинхорлоо, Ш. (2014). *Хүүхийн хөгжил*. Улаанбаатар: Хөх Монгол
- Чоймаа, Ш. (2015). *Монгол ёс заншил, уламжлалт ухаанаа заан сургагч нарт тус дэм*, Улаанбаатар: Соёмбо пресс
- Монголын нууц товчоо. (2009). *Хүүхдээ хэрхэн хүмүүжүүлэх вэ?*. Улаанбаатар: Мөнхийн үсэг групп
- Намжил, Т. (2005). *Монгол гэр бүлийн ёс, уламжлал*. Улаанбаатар: Соёмбо принтинг
- Намжил, Т. (2014). *Олон соёлт гэр бүл*. Улаанбаатар: Мөнхийн үсэг групп
- Пүрэв, О. (2013). *Монголын боловсрол, сургалтыг хүмүүншүүлэх онол, арга зүйн зарим асуудал*. Улаанбаатар: Бит Присс
- Сүхбат, Ш. (2009). *Монголчуудын сурган хүмүүжүүлэх өв уламжлал*. Улаанбаатар: Соёмбо принтинг
- Эрдэнэочир, Г. (1998). *Ардын сурган хүмүүжүүлэх зүй*. Улаанбаатар: Мөнхийн үсэг групп